



ОРХОН АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗАР



9001:2015



37001:2016

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 он





Төлөвлөгөөний биелэлт хянасан:

Төсвийн Төвлөрүүлэн захирагч

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

(гарын үсэг)

Б.БАТЖАРГАЛ

Тэмдэг

.....
(огноо)

Төлөвлөгөөг тайлагнасан:

Төсвийн шууд захирагч

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

.....
(гарын үсэг)

Д.НАРМАНДАХ

.....
(огноо)

**ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.							
Зорилт 1: “Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
1.1.	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах;	-	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд ирүүлсэн 15 чиглэл, 14 зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Нийгмийн даатгалын Хамралт орлогын чиглэлээр НДЕГ-ын даргын 2025 оны Маягтын загвар шинэчлэн батлах тухай А/204, А/281 дүгээр тушаал, НДЕГ-ын 2025.11.19-ний өдрийн 04/3061 тоот албан бичгээр өгсөн Ажил эрчимжүүлэх тухай чиглэл, НДЕГ-ын даргын 2025 оны А/244 тушаалаар өгсөн “Итгэлцлийн аян зохион байгуулах тухай”, А/197 тушаалаар өгсөн “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын менежментийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг тус тус ханган ажилласан. Мөн хяналт шалгалтын чиглэлээр 1 журам, 6 зөвлөмж, 5 үүрэг даалгавар, 2 албан даалгавар, 4 чиглэлийн ирсэн бөгөөд тухай бүр хэрэгжилтийг тайлагнаж, үр дүнг тооцож ажилласан. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой 2024.12.13-ны өдрийн 11/365 тоот чиглэл, 2025.06.02-ны өдрийн 04/1360 тоот зөвлөмжийн хэрэгжилтийг ханган	

						ажиллаж байна.	
1.2.	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах;	Тухайн аймаг, дүүргийн ҮА-ны зардлын төсөв	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хуваарийн дагуу төсвийг зарцуулсан байна.	Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардалд 1,559.0 сая төгрөг зарцуулсан.	Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна.	2025 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны урсгал зардалд 1,722.7 мянган төгрөг зарцуулахаас 1,602.5 мянган төгрөгийг зарцуулж 120.2 мянган төгрөгийг хэмнэж ажилласан.	
1.3.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын биелэлтийг хангах;	-	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоогоор	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх 0 арга хэмжээ зохион байгуулсан.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.	НДҮЗ-ийн 2024 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журмын дагуу НДЕГ-ын 2025.03.31 өдрийн 01/721 тоот албан тоот чиглэлийн дагуу Орхон аймгийн НДГ-ын даргын тушаалаар 6 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороог байгуулсан. ҮОМШӨ-с урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах мэргэжлийн байгууллагыг сонгох тухай урилгыг олон нийтэд нээлттэйгээр байршуулсан. Зарын дагуу сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт, материалаа ирүүлсэн байгууллагуудаас Орхон аймгийн ҮЭХ-ны дэргэдэх ХАБЭА-н сургалтын төв шалгарч тус газартай 2025.11.03-ны өдрийн №01 Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний хэрэгжилтийг 12 дугаар сарын 22-ны өдөр дүгнэхээр төлөвлөн ажиллаж байна.	
1.4.	Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах	-	2 удаагийн сэтгэл ханамжийн		Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн	Нэг цэгийн үйлчилгээгээр нийт 11854 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэж ажилласан.	

	ажлыг зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх;		судалгаа хийгдсэн байна.	-	сэтгэл ханамжийг 1-5 оноогоор дүгнэж, судалгааны үр дүнг албан бичгээр 6 дугаар сарын 10, 12 сарын 10-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлсэн байна.	Нийт үйлчилгээ авсан иргэдээс түүврийн аргаар 354 иргэнээс 10 асуулга бүхий сэтгэл ханамжийн судалгаа авахад гол асуулт болох үйлчилгээ шуурхай, хялбар байсан уу гэсэн асуултад 56.5%-н маш сайн, 36.7% дунд, 6.5%, муу, 0.3%, маш муу үнэлгээг өгсөн бол мэдээллээ бүрэн авсан уу гэсэн асуултад 95.8% тийм, 4.2% үгүй гэсэн үнэлгээ өгсөн, ажилтны харилцаа хандлага дээр 94.9% нь сэтгэл ханамжтай, 4.5% нь сэтгэл дундуур, 0.6% муу гэж үнэлсэн байна. Судалгааны тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газарт заасан хугацаанд хүргүүлсэн.	
--	---	--	--------------------------	---	--	---	--

Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Зорилт 2: “Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт,чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

2.1.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах.		НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ.	Нийгмийн даатгалын төвлөрсөн сангийн харилцах дансны орлого 177,050.3 сая төгрөгийг өдөр бүр төвлөрүүлсэн.	НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна.	НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллаж Нийгмийн даатгалын санд 2025 жилийн эцсийн байдлаар орлогын төлөвлөгөөг 218.8 тэрбум төгрөгөөр төвлөрүүлэхээс 189.3 тэрбум буюу 86.5 хувиар биелүүлж, ажилласан.	
2.2.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.		Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж төлбөр	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.	а) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу хуульд заасан	Тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардлын 253.6 тэрбум төгрөгийн төлөвлөгөөг 251.8 тэрбум буюу 99.31 хувийн биелэлттэй зарцуулсан.	

			зардлыг хугацаанд нь олгоно.		хугацаанд зарцуулсан байна. б) Төсвийн хуваарьт оруулах саналаа тухай бүр НДЕГ-т хүргүүлсэн байна. в) Нийгмийн даатгалын сан хариуцах шимтгэлийг гүйцэтгэлээр бүрэн шилжүүлсэн байна.		
2.3.	Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах.		Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана.	Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулсан.	а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх. б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна.	2025 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны урсгал зардалд 1,722.7 мянган төгрөг зарцуулахаас 1,602.5 мянган төгрөгийг зарцуулж 120.2 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.	
2.4.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах		Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, төсвийн	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн	Хуульд заасан цаглабарын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Аймгийн холбогдох байгууллагуудад санхүүгийн 12 удаагийн мэдээ, 4 удаа тайланг гаргаж хугацаанд нь хүргүүлж ажилласан.	

				зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж, ирүүлсэн.	гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.		
2.5.	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах.		Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийг захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана.	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна.	-Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах; -Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11	2025 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 06 сарын 14-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/92 тушаалыг үндэслэн тус газрын Өмч хамгаалах байнгын зөвлөл нь үндсэн хөрөнгийн тооллогыг журмын дагуу хийж тайлан, мэдээ, судалгааг холбогдох газруудад хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан. - Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” програмд оруулж ажилласан. - Хагас жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг гаргаж хүргүүлсэн. - Газрын даргын 2025.01.25 өдрийн А/3 дугаар тушаалаар тооллогын комисс томилогдон ажиллаж 2025 оны төлөвлөгөө батлуулан, өмч хөрөнгийн тооллого хийж дүгнэлт гарган даргын зөвлөлийн хуралд	

					маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх; -Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх;	танилцуулсан. - Ашиглалтын хугацаа дуусаж,эвдэрч гэмтсэн үндсэн хөрөнгийн судалгаатай гаргаж, актлах,хугацааг сунгах 22 нэр төрлийн 72 ширхэг 23,941,588 төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө жагсаалтыг дээд газарт хүргүүлсэн. -	
2.6.	Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах.		Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ.	а) Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.	а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна.	Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажилласан.	

2.7.	Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх.		Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.	Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан.	а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкуудтай байгуулсан 2024 оны гэрээг 2025.01.10-ны өдөр зүйл заалт бүрээр дүгнэж, биелэлтийг НДЕГ-т хүргүүлж ажилласан. 2025 онд хамтран ажиллах гэрээг 02 дугаар сард байгуулсан бөгөөд гэрээний хэрэгжилтийг 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор дүгнэж НДЕГ-т хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	
2.8.	Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх.		Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ.	Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн.	а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	Нийгмийн даатгалын системийн цахим мэдээллийн сан илүү ухаалаг түвшинд шилжиж байгаатай холбоотойгоор шинэ болон хуучин программ хангамжуудыг давхар ашиглаж алдаа, залруулга гаргахгүйгээр ажиллаж байна. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргалгүй ажилласан.	
2.9.	Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх.		ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core”	ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон.	Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна.	Шинэ системийн шинэчлэлт, сайжруулалттай холбоотой тулгамдсан асуудлуудыг Нийгмийн даатгалын газарт цаг тухай бүрд уламжлан Ай Ти Зон ХХК-ны программистуудаар алдааг засварлуулан ажиллаж байна. Тус газраас системийн 2025 онд 8 алдааг илрүүлж засварлуулсан. Системийн сайжруулах ажил хийгдэж байна.	

			системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ.				
2.10.	Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах		Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна	Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан.	а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна.	Нийгмийн даатгалын сангийн харилцах дансны үлдэгдлийг арилжааны банкнуудтай тооцоо нийлэн баталгаажуулж, сангийн бусад өглөг, авлагыг холбогдогч, байцаагч ажилтнуудаар улирал бүр гарын үсэг зуруулан баталгаажуулсан.	
Зорилт 2.1: “Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, сан бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, сайн дураар даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах, шимтгэлийн өр барагдуулах ажлыг зохион байгуулах ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нийгмийн даатгалын байгууллагуудыг мэргэжил, арга зүгээр хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
2.1.1.	Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Шаард-лагагүй	Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь	2024 онд 4798 хүнийг сайн дурын даатгалд, үүнээс 280 малчин хамруулав.	Сайн дурын даатгалд шинээр 543 хүнийг үүнээс 98 малчин шинээр хамруулж төлөвлөгөөг биелүүлсэн байна.	2025 оны жилийн эцсийн өдрийн байдлаар сайн дурын даатгалд нийт 4290 даатгуулагч хамрагдсан байна. Үүнд: - Энгийн сайн дурын даатгуулагч 3276 - Малчин даатгуулагч – 322 - Тэтгэмжийн даатгалын сангаас хариуцан төлж байгаа 0-3 хүртэлх настай хүүхдээ асарч байгаа эх – 398 - Улсын төсвөөс хариуцан төлж байгаа 0-3 хүртэлх настай хүүхдээ асарч байгаа эх – 324	

						- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг эцэг, эх даатгуулагч – 152 тус тус даатгуулсан байна. 2024 онд 127 малчин сайн дурын даатгалд хамрагдаж байсан бол 2025 онд 322 малчин хамрагдаж байгаа нь өмнөх оноос 195-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	
2.1.2.	Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Шаардлагагүй	Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь	2024 онд 1661 ажил олгогч, 30614 хүнийг албан журмын даатгалд хамруулав.	Ажил олгогчийн тоог шинээр 96, даатгуулагчийн тоог шинээр 570 хүнээр нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.	Хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр Татварын хэлтэс, Хүнс хөдөө аж ахуй газраас судалгаа мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж 2025 онд шинээр үүсгэн байгуулагдсан шинэ хоршооны судалгааг авч мэдээлэл түгээн ажилласан. 2025 онд 95 аж ахуй нэгж байгууллага хамруулж, даатгуулагчийн тоог 266-аар нэмэгдүүлэн ажилласан байна.	
2.1.3.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг 2025 оны эхний үлдэгдэлээс 30 доошгүй хувиар бууруулах;	-	Хуримтлагдсан авлагыг тухайн санхүүгийн бүрэн барагдуулсан байх	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 2024 оны жилийн эцэст 5895.37 сая төгрөгт хүрсэн.	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 1768.61 сая төгрөгийг /2.1.4-д зааснаас бусад шимтгэлийн авлага/ бүрэн барагдуулах. Шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах.	2025 онд нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагад ХНХСайдын А/199 -р журмыг хэрэгжүүлэн ажиллаж 740 аж ахуй нэгж байгууллагын 5,881,815.38 мян/ төгрөгийн шимтгэлийн өрөнд арга хэмжээ авч 553 байгууллагын 2,896,949.36 мян/төгрөгийг барагдуулан нийт өр, авлагыг 49.25 хувиар буруулан ажиллалаа. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Итгэлцлийн аян” ажлыг зохион байгуулах А/244 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах 414 аанб –ын 6,647.872,8 мян төгрөгийн өр авлагаас - 41 байгууллагатай гэрээ байгуулж 191,801.3 мян төгрөг, сая төгрөг	

						- 8 байгууллагатай гэрээ сунгаж 252,780.04 мян төгрөг, - 13 байгууллагын данс гүйлгээг түр зогсоож 132,509.36 мян төгрөг 175 байгууллагын хуримтлагдсан авлагаас 875,395.96 мян төг буюу нийт 1,452,486.75 мян төгрөг буюу аяны хүрээнд 21.8 хувь барагдуулан ажилласан байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэн Уулзалт: - Нийт 109 байгууллагад зохион байгуулан 89 байгууллагын 2 660 541.1 мян төгрөгийг барагдуулан Албан шаардлага: - Нийт 159 байгууллагад хүргүүлснээс 22 байгууллагын – 176 257.85 мян төгрөг Данс хаасан: - Нийт 205 байгууллагын 8 235 941.76 мян төгрөгөөс 111 байгууллагын 837 456 737 мян төгрөг Гэрээ: - Нийт 86 байгууллагыг 1 109 877.68 мян төгрөгийн өр авлагаас байгуулж 47 байгууллагын 249 870. 74 мян төгрөг Шүүхэд: - Нийт 3 байгууллага шилжүүлж гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын 8 тойргийн 13 байгууллагын 14 захирамжийн 855
--	--	--	--	--	--	---

						067.32 мян төгрөгийн шимтгэлийн авлага, 330350 мян төгрөгийн алдангид барагдуулалтын явцыг хэлэлцэн 4 байгууллагын 41177.84 мян төгрөгийн авлага барагдуулан хамтран ажилласан байна.	
2.1.4.	Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулсан байх;		Шимтгэлийн өргүй гарсан байх.	Төсөвт байгууллагын шимтгэлийн өр 213.25 сая төгрөг, орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өр 40.9.сая төгрөг байна.	Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулж шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах.	2025 оны эхэнд төсөвт байгууллагын шимтгэлийн өр, авлага 14 байгууллагын 132914.4 мян.төгрөг байсныг бүрэн барагдуулсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар төсөвт байгууллагын Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага барагдуулахад анхааран ажиллаж байна. Бүсийн оношлогоо эмчилгээний төв 859,817.6 сая төгрөгийн НДШ-ийн өртэй гарах тооцоололтой байна. Энэ нь Эрүүл мэндийн яамнаас баталсан төсөвтэй хамааралтай өр үүссэн байна.	
2.1.5.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажил зохион байгуулах.	-	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу орлогын гүйцэтгэл 100% хангуулна.	Нийгмийн даатгалын санд 173,2 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулав.	Нийгмийн даатгалын санд 217,8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлнэ.	Нийгмийн даатгалын санд 2025 жилийн эцсийн байдлаар орлогын төлөвлөгөөг 217.8 тэрбум төгрөгөөр төвлөрүүлэхээс 189.3 тэрбум буюу 86.5 хувиар биелүүлж, ажиллалаа.	
2.1.6	UBCab компанитай хамтран ажиллаж гэрээт гүйцэтгэгч, жолооч нарыг сайн дурын даатгалд хамруулах		Нийгмийн даатгалд хамруулсан иргэдийн тоо	-	Системийн хэмжээнд сар бүр 23070 даатгуулагчийн 2.5 тэрбум төгрөг, жилд 29.6 тэрбум төгрөгийн сайн дурын даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлэхээр зорьж байна.	Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны ажилтнуудын зөвлөгөөнд шинэ санал гаргаж танилцуулсан. UBCab компани программын хөгжүүлэлтэд хийгдээгүй байна.	

				Үүнээс Орхон аймагт сар бүр 1100 даатгуулагчийн 117.6 сая төгрөг, жилд 705.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлнэ.		
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт						
Зорилт 3: “Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:						
3.1.	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих;	-	- Мэдээлэл байршуулалтыг 100 хувьд хүргэнэ.	Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 2024 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй байна.	Байгууллагын мэдээллийг үнэн зөв, бодитой мэдээлж мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдан иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна.	Байгууллагын 48 мэдээллийг веб хуудас, фэйсбүүк хаяг, мэдээллийн 6 самбарт байршуулсан мэдээлэлд улирал бүр хяналт тавьж, дутуу болон шинэчлэх шаардлагатай мэдээллийг залруулж, дараагийн шатны байгууллагаар улирал бүр дүгнүүлэн ажиллаж байна. Үнэлгээ авсан байдал: 1-р улирлын үнэлгээгээр 96% үнэлүүлсэн. 2-р улирлын үнэлгээгээр 99% үнэлүүлсэн. 3-р улирлын үнэлгээгээр 99% үнэлүүлсэн. 4-р улирлын үнэлгээ хүлээгдэж байна.
3.2.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуултад хяналт тавих;	-	- Сар бүрийн хугацаанд байршуулсан мэдээлэл 100 хувь байна. - Шилэн дансны хөтөлөлтийн тайлан /4/-г байгууллагын цахим хуудаст	Шилэн дансны хөтөлөлтийн 2024 оны нэгдсэн тайлангаар мэдээлэл байршуулалт 99 хувьтай байна.	Нийгмийн даатгалын байгууллагын санхүү үйл ажиллагаа болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж,	Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны 171 мэдээлэл байршуулахаас хуулийн хугацаанд бүрэн 149 мэдээлэл байршуулж, 1 мэдээлэл хоцорч байршуулсан. Нийгмийн даатгалын сангийн 159 мэдээлэл байршуулахаас хуулийн хугацаанд бүрэн 141 мэдээллийг байршуулсан.

			Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор мэдээлсэн байна.		иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна.	Нийт 290 мэдээллийг байршуулж, 1 мэдээллийг хоцроож хугацаандаа 99,6% байршуулан хэрэгжүүлэн ажиллаж, цахим хуудсанд тайланг улирал бүр мэдээлсэн. Шилэн дансны цахим хуудсанд тавих хяналтыг улирал бүр хийж, шалгалтын явцад мэдээллийн үнэн зөв бүрэн бүтэн оруулсан байдлыг шалгахад илүү мэдээлсэн 13 гүйлгээний 9,228.5 сая төгрөгийн мэдээллийг засаж, дутуу мэдээлсэн 24 гүйлгээний 14,207.9 сая төгрөгийн гүйлгээг нөхөн байршуулж нийт 37 гүйлгээний 23,436.4 сая төгрөгийн гүйлгээний зөрчлийг арилгаж 100% хэрэгжүүлэн ажилласан.	
Зорилт 3.1: “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
3.1.1.	Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад болон газрын үйл ажиллагаа, сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллах,	-	- Шалгасан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хамрагдалтын хувь, - Шалгалтад хамрагдсан нийгмийн даатгалын сангийн тоо, мэдээлэл, Илэрсэн төлбөр, зөрчлийн баргадуулалтын хувь.	2024 онд 106 байгууллагад хяналт шалгалт хийж, 30 зөрчлийг хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулж, 25 улсын байцаагч акт 95% барагдуулж ажилласан. Сангийн зарцуулалтад шалгалт хийж илэрсэн зөрчлийн 74%-ийг барагдуулсан.	Шалгалтын үр дүнг тухай бүрт тооцон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарган, актын барагдуулалтын мэдээ, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна.	Дотооддоо 7 чиглэлээр хяналт шалгалт хийж 4 зөвлөмж, 2 албан шаардлага, 79.00 сая төгрөгийн зөрчилд 2 улсын байцаагчийн акт үйлдэж 57.9 сая төгрөгийг буюу 73.2% барагдуулсан. - Ажилгүйдлийн сан - Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт - Байгууллагын үйл ажиллагааны зардал - Тэтгэврийн даатгалын сан - Жаргалант сумын үйл ажиллагаа - Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа - 2024-2025 оны Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хийсэн залруулга,	

						нөхөн тайлагнасан үйл ажиллагаа Гадагшаа 3 чиглэлээр хяналт шалгалт хийж 28.54 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн ажиллаж 100% барагдуулсан. - Нийгмийн хамгааллын салбарын хяналт - Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдэд төлөвлөгөөт хяналт шалгалт - Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгах Нийт 107.54 сая төгрөгийн төлбөрийн зөрчлөөс 86.44 сая төгрөгийг буюу 80,37% барагдуулж ажилласан.	
3.1.2.	Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах;	-	Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгасан байна.	-	Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.	НДЕГ-ын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн баталсан удирдамжийн дагуу Их, дээд болон коллежийн, түүнчлэн ерөнхий боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн жагсаалтаар ирсэн нийт 6 байгууллагыг бүрэн шалгаж Нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж 78.31 сая төгрөгийн цалингийн сангаас 5.87 сая төгрөгийн шимтгэл, 1.90 сая төгрөгийн алданги, нийт 7.78 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж 100%-ийг барагдуулж ажилласан.	

3.1.3.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах;	-	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагуудыг шалгасан байна.	-	Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.	НДЕГ-ын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн баталсан удирдамжийн дагуу Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн жагсаалтаар ирсэн нийт 6 байгууллагыг бүрэн шалгаж Нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж 78.55 сая төгрөгийн цалингийн сангаас 10.15 сая төгрөгийн шимтгэл, 2.58 сая төгрөгийн алданги, нийт 12.74 сая төгрөгийн зөрчлөөс 11.25 сая төгрөгийг буюу 88.3%-ийг барагдуулж ажилласан.	
3.1.4.	Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж үр дүнг тооцох, тайланг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх;	Батлагдсан төсвийн хүрээнд	-Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь -Илрүүлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, -Шалгалтын тайланг хугацаанд Хяналт	-	Ажилгүйдлийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгаж, үр дүнг тооцож, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажилласан байна.	ГБХНХЯ-аас 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн баталсан 13-07/06 дугаартай удирдамжийн дагуу Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны зарцуулалтыг шалгах ажлын хүрээнд 2762 ажилгүйдлийн хувийн хэргийн бодолт, олголтыг шалгахад 52.0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, улсын байцаагчийн акт үйлдэж 21.6 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг 18 даатгуулагчид нөхөн олгож, 30.3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг	

			шалгалтын газарт хүргүүлсэн байна.			28 даатгуулагчид илүү олгосноос 11.3 сая төгрөгийг барагдуулж зөрчлийг арилгах арга хэмжээ авч дөрөвдүгээр улирлын байдлаар 32.9 сая төгрөгийг барагдуулсан нь 63.27%-ийн биелэлттэй байна.	
3.1.5.	Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нэр бүхий 351 объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх;	Батлагдсан төсвийн хүрээнд	Эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, -Удирдамжийн хугацаанд мэдээ тайланг нэгтгэж, тайланг Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна.	2024 онд 15 объектод хяналт шалгалт хийж, 2 зөрчил илрүүлж, 2 албан шаардлага хүргүүлж ажилласан.	Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	Төлөвлөгөөт тусгасан 15 байгууллагаас хуваарийн дагуу 14 объектод хяналт шалгалт хийж, 3 албан шаардлага өгч, 1 байгууллагад зөрчлийн тухай хуулийн дагуу 5.0 сая төгрөгийн торгууль оногдуулан 100% барагдуулж, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан.	
3.1.6.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх,	-	- Хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь, - НДЕГ-т хүргүүлсэн тайлан, мэдээний тоо,	Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээг НДЕГ-т хүргүүлж ажилласан.	Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр днг тооцож, тайланг улирал тутамд гарган Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулан гаргасан. - НДЕГ-ын тэтгэврийн даатгалын сангийн тогтоолт, олголтод хийсэн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр: а/ 2.59 сая төгрөгийн актаас 0.51 сая төгрөгийг буюу 19,69% барагдуулсан. б/ 220,09 сая төгрөгийн олголт зогсоох актаас санд төлүүлэх дүн 210,87 сая төгрөг тогтоосноос 185,12 сая төгрөг буюу 87,78%	

					ажилласан байна.	барагдуулсан. - Дотооддоо 7 чиглэлээр хяналт шалгалт хийж 3 зөвлөмж, 2 албан шаардлага, 79.00 сая төгрөгийн зөрчилд 2 улсын байцаагчийн акт үйлдэж 57.9 сая төгрөгийг буюу 73,29% барагдуулсан. - 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас 34.14 сая төгрөгийн зөрчлийг давтан гарахгүй байх албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажиллах 4 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг газрын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 100% хангаж ажиллаж, тайланг хүргүүлсэн.	
3.1.7.	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх;	-	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэх, төлбөр, зөрлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, үр дүнг тооцож ажиллах,	Дотоодын хяналт, шалгалтын тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр гаргуулж, нэгтгэн төлбөр, зөрлийн барагдуулалтад хяналт тавьж ажилласан.	Шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн. Нийт төлбөр зөрчлийн 628,59 сая төгрөгөөс 315,1 сая төгрөгийг буюу 50.2% барагдаж, барагдаагүй үлдсэн дүнгээс өр авлагатай 2 байгууллагын 183,61 сая төгрөгийг барагдуулахаар шүүхийн шатанд, өр авлагатай 1 байгууллагын 82,4 сая төгрөгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэн барагдуулж ажилласан. Нийт 55 зөрчлийн хэрэг бүртгэлийн	

						ажиллагаа явуулж 44 байгууллагад 23.6 сая төгрөгийн торгууль оногдуулснаас 21.1 сая төгрөгийн торгуулийн дүнгээс 50% хөнгөлж, үлдсэн 50%-ийг бүрэн төлүүлэн барагдуулж ажилласан.	
Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.							
Зорилт 4: “Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.1.	Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх;		- 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна. -Арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн	2024 онд тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, биелэлтийг нэгтгэн авч, дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 89,4%-тай хэрэгжсэн байна.	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангагдсан байна.	- МУ-ын Засгийн газрын 2025.01.02-ны өдрийн “Эрүүл мэндийн магадлалын хувь хэмжээ тогтоох тухай” 02 дугаар тогтоол - Монгол улсын Засгийн газрын 2025.01.22-ны өдрийн 05 дугаар хуралдааны тэмдэглэл - МУ-ын Ерөнхий сайдын 2025.03.06-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар албан даалгавар - Мөн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбогдуулан 2025 оны эхний хагаст орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 03 дугаар албан даалгавар - Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025.02.07-ны өдрийн ҮОМШӨ-ний даатгалын сангаас санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 06 дугаар тогтоол - ГБХНХЯ-ны сайдын 2025.02.25-ны өдрийн “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлэн ажиллах тухай” 03	

						дугаар албан даалгавар - Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны “Ажлын хариуцлага, сахилга дэг журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай” 01 албан даалгавар тус тус хяналтад авч хэрэгжилтийг 100% хангаж ажилласан. Мөн НДЕГ-ын даргын 25 тушаал, 5 зөвлөмж, 2 хугацаатай үүрэг даалгавар, 4 чиглэлийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажилласан. 2025 оныг “Нийгмийн даатгалын өр, авлага барагдуулах жил” болгон зарласантай холбогдуулан Нэрэмжит жилийн төлөвлөгөөг 3 зорилт 28 арга хэмжээтэйгээр төлөвлөн ажиллаж биелэлтийн сар бүр хүргүүлэн ажиллаж байна.	
4.2.	Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;		-Улирал бүрийн 20-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлнэ. -Өргөдөл шийдвэрлэлтийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн түвшин хэмжээнд 2024 онд 100%-тай хэрэгжсэн байна.	Иргэд, даатгуулагч, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, шийдвэрлэлтийн мэдээг үнэн зөв гаргаж, хүргүүлсэн байна.	Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас 2025 оны 12 дугаар сарын байдлаар нийт 317 өргөдөл, 0 санал ирснээс хуулийн хугацаа болсон 297 өргөдлийг бүрэн шийдвэрлэж хариуг хуулийн хугацаанд өгч ажилласан. 20 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна. Өргөдөл хүсэлтийн мэдээг сар бүр буюу нийт 12 удаа, тайланг 4 удаа гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. Шийдвэрлээгүй буюу, хугацаа хоцроож шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо 0 байна. Шийдвэрлэлтийн хувь 90%	

4.3.	Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх;		Төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргасан байна.	Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор ханган ажилласан.	Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргах, Нийгмийн даатгалын ерөнхий газарт орон тооны мэдээг сар бүр тайлагнасан байна.	2025 оны 12 дугаар сарын байдлаар орон тооны болон цалингийн сангийн хэтрэлтгүй ажилласан. Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2025 оны А/239 дүгээр тушаалаар тус газрын орон тоог 36-аар баталсан бөгөөд гүйцэтгэлээр 35 албан хаагч ажиллаж байна. 2025 оны эхний хагаст 2 сул орон тоо гарсан. Нэг цэгийн үйлчилгээний байцаагчийн орон тоог Төрийн албаны тухай хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулж төрийн албаны нөөцөөс нөхсөн бол, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтний орон тоог төрийн өөр байгууллагаас шилжүүлэн авч ажиллуулах журмын дагуу нөхсөн. Орон тооны гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 05-ны өдрийн дотор дээд шатны байгууллагад тайлагнан ажиллаж, хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж ажилласан.	
